



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын 10/5177 тоот дүгнэлт, Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид тогтоосон хэмжээ, солбицолын дагуу 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг "Майн альтернатив сольюшн" ХХК (М.Чимэддорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100527